

ҮНДЭСНИЙ ТАТВАРЫН АЛБАНЫ АВИЛГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2014 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 дүгээр сарын 26

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Төр засгийг түмэн олондоо тунгалаг, нээлттэй болгож, хариуцлага, хяналтыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгон мөрдүүлж, хүнд сурталгүй, авлигаас ангид төрийн үйлчилгээг бий болгож, улмаар төрийн албыг нийтийн алба, төрийн үйлчилгээг нийтийн үйлчилгээ болгон үндсээр нь өөрчилж, хууль дээдлэн, хүн бүр эрх тэгш, эх орондоо, аймаг, хотдоо сайхан амьдрах нийгмийг цогцлооход авлига, хүнд сурталтай хийх тэмцэлд эрс шинэчлэл гаргах; авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, нийтийн албаны үйл ажиллагааг иргэдэд хүнд сурталгүй, ил тод, алагчлалгүй, шударга, хүртэмжтэй болгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ гэж заасан билээ.

Авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөнд тусгагдсан хэрэгжүүлэх арга хэмжээг Татварын бүх албад идэвхи санаачлагатай өрнүүлэх нь нийгмийн дунд үүсээд байгаа Татварын албанд үл итгэх, татварын албаны албан хаагчид гэж авлига аваад сууж байдаг гэсэн ойлголтыг няцаах эргээд нийгэмд эерэг сэтгэгдэл төрүүлэх болон “Татварын алба сайн засаглал хөгжсөн авлигагүй алба” болоход бидний нэг санаатай хамтын хүчин зүтгэл хамгаас чухал юм.

“Татварын алба-Авлигагүй алба” болоход Татварын албаны бүх албан хаагчдын ёс зүйтэй байдал Төрийн албан хаагчийн болон Татварын ажилтны ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа баримтлан харилцааны соёлыг эрхэм болгон ажиллахыг Татварын албанд ажиллаж буй татварын улсын /ахлах/ байцаагчид, хураагчид, орон тооны бус ажилтнууд, туслах ажилтнуудаас шаардан ажиллаж байна. Ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд хуулийн дагуу арга хэмжээг нэн даруй авах арга хэмжээ авч ажиллаа.

Татварын алба бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан, нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаварыг нь арилгах арга хэмжээ авах, бүх шатны албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой асуудлыг шалгаж шийдвэрлэх нь өөрийнх нь бүрэн эрхэд хамаарахгүй байвал Авлигатай тэмцэх газарт хууль, дүрэм, журмын дагуу мэдээлэн ажиллахаар Татварын ерөнхий газрын даргын 2012 оны “хууль, журам хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тушаалын дагуу хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.

Нэг. Хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийн талаар

1.1 Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх нь

Үндэсний татварын албаны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган Татварын ерөнхий газрын даргаар батлуулж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна. Мөн харъяа аймаг, нийслэл, дүүргийн татварын албад тухайн албандаа хэрэгжүүлэх Авлигын эсрэг төлөвлөгөө боловсруулан ажиллаж, хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр тайлагнаж хэвшээд байна.

1.2 Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах

Татварын улсын байцаагчдын эрх олгох, сунгах, тасралтгүй сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвээр сургалтын хөтөлбөр боловсруулан оруулж татварын ажилтан, албан хаагчдад авлигыг үл тэвчих ёс суртахууныг төлөвшүүлэхэд хамтран ажиллах саналыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсний үндсэн дээр татварын улсын байцаагчийн эрх олгох сургалтанд Авлига, ашиг сонирхлын зөрчлийн тухай болон, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар сургалтын хөтөлбөрийг АТГ-тай хамтран боловсруулж 2013 оноос сургалтын хөтөлбөрт оруулан сургалт явуулж эхлүүлээд байна. (Татварын улсын байцаагчийн эрх олгох энэхүү сургалтанд хамрагдаж шалгалт өгч тэнцсэн 47 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтын дагуу АТГ-т хүргүүлж дүгнэлт гаргуулсан)

Мөн Нийслэл, орон нутгийн татварын албад албан хаагчиддаа Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар яриа таниулга хийж, Авлигын эсрэг хууль тогтоомжийн эмхэтгэл бүхий самбар, зурагт хуудсыг ажлын байранд байрлуулсан.

1.3 Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох

Татварын хуулиудын шинэчлэлт, өөрчлөлт хийхэд татвар төлөгчдөөс вэб сайтаар болон цаасаар судалгаа аван, боловсруулж, хууль санаачлагчдад саналаа хүргүүлэн ажилладаг ба Татварын ажилтны ёс зүйн дүрэм, Ёс зүйн хорооны ажиллах журам, УТА-ны хөдөлмөрийн дотоод журмын төслийг цахим хуудсанд байршуулан холбогдох этгээдээс санал, дүгнэлт авч тусган ажиллаа.

Татварын албаны үйл ажиллагаа болон үйлчилгээний талаарх санал асуулгыг цахимаар авч байна. Санал асуулгын үр дүн татвар төлөгчид болон бусад сонирхогч бүлгүүдэд нээлттэй харагддаг бөгөөд дутагдалтай байгаа үйл ажиллагааг сайжруулах боломжийг бүрдүүлж өгсөн.

1.4 Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах

Тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлыг “Үндэсний татварын албаны хяналт шалгалтын ажлын дүрэм”-ийн дагуу хийж гүйцэтгэж байгаа бөгөөд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төлөвлөгөө, татварын хяналт шалгалтанд хамруулах татвар төлөгчдийн эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн үнэлгээний програмаар тооцож татвар телегч аж ахуйн нэгж 126571, иргэн 1096783, бүгд 1223354 татвар телегчийн эрсдэлийг эрсдэлийн удирдлагын програмаар инэлж эрсдэл ендертэй 60 татвар төлөгч, дунд эрсдэлтэй 3890 татвар төлөгч, бага эрсдэлтэй 2600 татвар төлөгч, зөвшөөрч болохуйц эрсдэлтэй 102 татвар төлөгч инэлэгдсэн. «Үндэсний Татварын албаны эрсдэлийн үнэлгээний дүрэм»-ийн холбогдох заалтын дагуу Татварын албадаас санал авч дээрх эрсдэлтэй татвар төлөгчдийг оролцуулан 10951 аж ахуйн нэгж, байгууллага буюу 8.65 хувь, 1068 хувь хүн буюу 0.10 хувь, нийт 12019 татвар төлөгч буюу татвар төлөгчдийн 0.98 хувийг татварын хяналт шалгалтанд хамруулахаар төлөвлөсөн.

Татвар төлөгчид нь нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримт болон Нэмэгдсэн өртгийн албан татварын падаан бусад үнэт цаас, тооцоот маягт, хэвлэмэл хуудсыг хуурамчаар бичих явдлуудыг таслан зогсоох ажлыг тусгай удирдамжаар зохион байгуулах ажлын хүрээнд ТЕГ-ын даргаар 2014 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн Дугаар А/37 тушаал болон “Хяналт шалгалт хийх удирдамж” батлуулан шалгалтын ажлын хэсэг байгуулж шалгалтын ажлыг зохион байгуулсан.

Татвар төлөгчийн албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж зөвшөөрөөгүй буюу маргаантай акт, дүгнэлт гарсан тохиолдолд түүнийг шийдвэрлэгдэх хүртэл Татварын маргаан таслах зөвлөл, бүх шатны шүүх, хууль хяналтын байгууллагад тайлбар лавлагаа өгөх, шүүх хуралд оролцох зэрэг арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж байна.

Татварын хяналт шалгалтанд хамрагдаж байгаа татвар төлөгчид “Татварын шалгалт хийгдэх үед анхаарах зөвлөмж”-ийг татварын албаны вэб сайт, мөн хяналт шалгалтын нэгжийн өрөөнд плакат хэлбэрээр байршуулан, гарсан зөрчлийн талаар мэдэгдэх АТГ-ын 18001969, ТЕГ-ын гомдол мэдээлэл хүлээн авах 11318895 утсыг нүдэнд харагдахуйц газруудад байршуулсан.

1.5 Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх

Тухайн жилийн төсвийг батлагдсаны дараа “mta.mn” вэб сайтад байршуулан мэдээлж, 2013 оны жилийн эцсийн тайланг хуулийн хугацаанд нь гарган Үндэсний аудитын газраар хянуулан, Сангийн яаманд нэгтгүүлсний дараа аудитын дүгнэлт, Нэгдсэн тайлан, 2014 оны төсвийн төлөвлөгөөг “mta.mn” вэб сайтад байршуулан, Мэдээллийн самбарыг шинээр хийж түүнд бүрэн эхээр нь оны турш байршуулан олон нийтэд мэдээлж ил тод байдлыг хангаж ажиллаа.

1.6 Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах

Татварын албаны хэмжээнд сул орон тоо гарах бүрт Төрийн албаны тухай хууль, Татварын ерөнхий хууль, холбогдох журам зааврын дагуу харъяа татварын албад Төрийн албаны салбар зөвлөлд сул орон тооны захиалга хүргүүлэн нөөцөд байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй иргэнийг санал болгох эсвэл ажлын байрны зарыг зарлуулан төрийн албан хаагчийн шалгалт авч тэнцсэн албан хаагчийн нэрийг томилуулахаар ТЕГ-т хүргүүлэн ажиллаж байна. Татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлийн дагуу тухайн иргэнийг 1 жилийн туршилтын хугацаанд хураагчаар томилдог. Тухайн албан хаагч туршилтын хугацаандаа татварын улсын байцаагчийн эрх олгох сургалтанд хамрагдан шалгалт өгч тэнцсэн тохиолдолд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн дагуу “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг”-ийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн, ашиг сонирхлын зөрчил үүсээгүй нөхцөлд тухайн албан тушаалд томилон ажиллаж байна.

Удирдан зохион байгуулах, гүйцэтгэх албан тушаалд ажлын дадлага туршлагатай, мэргэжил мэдлэгийн өндөр чадавхитай, ёс зүйн төлөвшил, харилцааны соёлтой, багаар ажиллах чадвартай хүний нөөцийг бүрдүүлж, ажлын үр дүнг дээшлүүлэх, ажлын гүйцэтгэлийг сайжруулах, албан тушаал дэвшүүлэх, сонгон шалгаруулах, шилжүүлэх, сэлгэж ажиллуулах, цалин хөлс, шагнал урамшууллыг оновчтой болгох, ирээдүйн хүний нөөцийн хэрэглээ шаардлагыг хангаж ажиллах гол зорилго бүхий “Үндэсний татварын албаны хүний нөөцийн бодлого” боловсруулах ажил хийгдэж, эхний байдлаар

төсөл нь гараад газар, хэлтсүүдээр хэлэлцүүлэгдэж байна. Уг бодлого нь татварын албаны хүний нөөцийн удирдлагыг ил тод, нээлттэй байдлыг хангах чухал арга хэмжээ болох юм.

1.7 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах

2014 онд хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа Сангийн Яамны Худалдан авах ажиллагааны газарт хийгдэх болсон. Худалдан авах ажиллагааны газарт 2014 онд Татварын албадад нийлүүлэх “Цахим татвар программ хангамж, техник, тоног төхөөрөмж худалдан авах, сүлжээг сайжруулах” захиалгыг гарган өгч 1,8 тэрбум төгрөгийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тэндэрийг зарласан. Онцгой албан татварын тэмдэг хэвлүүлэх, нийлүүлэх, иж бүрдэл программ хангамж бүхий хяналтын систем нэвтрүүлэх тендер зарлан хуулийн дагуу явууллаа.

1.8 Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох

Үндэсний татварын албаны ажилтан албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг Төрийн албаны тухай хуулийн зүйл заалтын дагуу ажлын байрны тодорхойлолтонд тухайн ажлын байрны чиг үүрэг, үндсэн зорилт, шалгуур үзүүлэлт, гол үйл ажиллагаа, тусгай шаардлага, харилцах субъект, хүлээх хариуцлага, нөхцөл, хэрэгсэл зэргийг тодорхой зааж тухайн нэгжийн ахлах болон дарга нь баталгаажуулан мөрдөн ажилладаг.

Мөн үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлэх, төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, сонирхлын зөрчилгүй ажиллах талаар албан хаагчийн тухайн жилд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхой болгон үр дүнгийн гэрээг оны эхэнд байгуулан ажиллаж байна.

Татварын Ерөнхий газрын албан хаагчдын овог нэр, эрхэлж буй албан тушаал, өрөөний дугаар, холбогдох утасны жагсаалтыг цахим хуудсанд байршуулан ажиллаж байна. Үндэсний татварын албаны албан хаагчдын утасны нэгдсэн жагсаалтыг тухай бүр шинэчлэн гаргаж байна. ТЕГ-ын удирдлагуудтай уулзаж санал бодлоо илэрхийлэх ажлыг нээлттэй болгож, иргэдийг хүлээн авч уулзах цагийг өдөр бүр хүлээн авч уулзах боломжийг бүрдүүлсэн.

1.9 Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах

2014 оны 05 дугаар сарын 14-ний өдөр МҮХАУТанхим, АТГ-аас зохион явуулсан “Авилгаас урьдчилан сэргийлэх нь: Татварын алба болон бизнес эрхлэгчид” сэдэвт хэлэлцүүлэг, 2014 оны 06 дугаар сарын 27-ны өдөр “Баянзүрх консалтинг” хуулийн фирмийн Авилгын эсрэг НҮБ-ын конвенцийн 5 бүлэг “Хөрөнгө буцаан олгох”-ийн Монгол Улсад хийгдсэн мониторинг ажлын хэсгийн уулзалтанд оролцож, Үндэсний татварын албанаас авилгын эсрэг хийгдэж байгаа ажлын хэрэгжилтийн талаар танилцуулж, учирч байгаа бэрхшээлтэй асуудал, цаашид хийх ажлын талаар санал гарган оролцлоо.

Ил тод байдлын сан ТББ-тай хамтран www.ilzasag.mn сайтад байгууллагын дэлгэрэнгүй мэдээллийг байршууллаа.

1.10 Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх

Татварын албаны хэмжээнд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах 32 эрх бүхий албан тушаалтан ажиллаж байна. Татварын албадуудад “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын “гурав”-ын 3.1 дэх заалтын дагуу тухайн албаны захиргаа, хуулийн асуудал эрхэлсэн албан тушаалтанд мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах ажлыг тушаал шийдвэрээр хариуцуулан томилж, түүнд албан тушаалын цалинг 25 хүртэл хувиар нэмэгдүүлэн олгож байна.

Авлигын асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон үр дүнгийн гэрээнд тусган оруулсан. Мөн “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын “гурав”-ын 3.2 дахь заалтын дагуу томилогдсон эрх бүхий албан тушаалтнуудаас хувь хүний нууцтай холбогдох мэдээллийг чандлан хадгалах, хамгаалах нууцын баталгаа гаргуулан авсан.

Үндэсний татварын албанд хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах, тайлагнах ажил хариуцсан 32 эрх бүхий албан тушаалтан ажиллаж байна. Татварын алба бүрт ажиллаж буй эрх бүхий албан тушаалтнууд Авлигын эсрэг хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа хууль журамд заасан хугацаанд ирүүлсэн.

1.11 Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх

Үндэсний Татварын ерөнхий газрын даргын 2014 оны 06 дугаар сарын 25-ны А/200 дугаар тушаалаар “Монгол Улсын Татварын ажилтны ёс зүйн дүрэм”-ийг батлан нийт татварын улсын байцаагч нарт танилцуулж, байцаагчдаар судлуулж, дагаж мөрдөхийг анхаарууллаа. Уг дүрмийг нийт татварын ажилтан бүрт танилцуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулах ажлыг тухайн үед зохион байгуулсан билээ. Уг дүрмэнд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зүйл заалтууд багтсан байдаг. Шинээр татварын улсын байцаагч болж буй албан хаагч бүрт Төрийн захиргааны албан хаагчийн ёс дүрэм, Татварын ажилтны ёс зүйн дүрмийг танилцуулан, танилцсан тухай гарын үсэг зуруулж баталгаажуулах ажил Татварын албаны хэмжээнд хэвшээд байна.

Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах тусгай утас, “Санал хүсэлтийн хайрцаг”-ийг нийслэл, орон нутгийн татварын албадууд дээр байрлуулан ажиллаж байна. Татварын албаны хэмжээнд татвар төлөгчдөөс татварын ажилтан албан хаагчдын ёс зүй, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл, санал хүсэлтыг 318895 дугаарын утсаар, өргөдөл, албан бичгээр, шинэчлэлийн Засгийн газрын “11-11.mn” сайтаар хүлээн авч байна.

12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар шинэчлэлийн Засгийн газрын “11-11.mn” сайтанд 28, 318895 дугаарын утсаар 14, албан бичгээр, өргөдөл, хүсэлтээр 38, нийт 80 мэдээлэл ирснийг судалж хариу мэдэгдэн, харъяалагдах хэлтэс, тасгийн дарга нарт нь мэдэгдэж ёс зүйн зөрчилгүй харилцааны доголдолгүй ажиллахыг гомдолд дурдагдсан татварын улсын /ахлах/ байцаагч нартаа анхааруулж ажиллахыг сануулж, гомдол гаргасан иргэдэд эргэж хариуг мэдэгдэж, шаардлагатай тохиолдолд дотоод хяналт шалгалтын ажлыг явуулж төрийн захиргааны албан хаагчийн болон татварын ажилтны

ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд танилцуулга бичиж ТЕГ-ын Ёс зүйн хороогоор асуудлыг шийдвэрлүүлэхээр санал оруулан ажиллаж байна.

Татварын ажилтан албан хаагчдын ёс зүйн зөрчлийн мэдээг хагас бүтэн жилээр гаргаж Төрийн албаны зөвлөлд хүргүүлж байна.

2014 онд Татварын албаны хэмжээнд 31 татварын ажилтанд сахилгын шийтгэл ногдуулсан байна

1.12 Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18, 19, 20 дугаар заалтыг хэрэгжүүлэх үүднээс Үндэсний татварын албаны албан хаагчдын давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гарган е-оффис программд байршуулан, Увс аймгийн Засаг даргаас ирсэн хүсэлтийг АТГ-аар хянуулан, санал хүргүүлж ажиллалаа.

1.13 Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах

Татварын ерөнхий газрын удирдлагаас гаргаж буй шийдвэрүүдийн ил тод, нээлттэй, шуурхай байдлыг хангах зорилгоор е-оффис программд тогтмол байршуулж, биелэлтийг танилцуулж хэвшээд байна.

Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг Татварын албаны цахим хуудас mta.mn сайтанд байршуулан нэмэлт өөрчлөлт орсон болон шинэчлэгдсэн тухай бүр өөрчлөлтийг тусган оруулж олон нийтэд сурталчлах ажил хэвшээд байна.

Татварын албаны үйлчлүүлэгчээс авч буй үнэт цаасны үнийг mta.mn цахим хуудсанд байршуулсан. Үүнд: онцгой албан татварын тэмдгийн үнэ, татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтрийн үнэ, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгчийн гэрчилгээний үнэ, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр төлөгчийн гэрчилгээний үнэ, нэмэгдсэн өртгийн албан татварын падааны үнэ зэргийг байршуулсан болно.

1.14 Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах

Иргэдийн өргөдөл / санал, мэдэгдэл/, гомдол хүсэлтийг 318895 дугаарын утас болон 1288 тоот утсаар авдаг бөгөөд энгийн тарифтай тусгай дугаарын баннерыг mta.mn цахим хуудасны нүүр хэсэгт тогтмол байршуулж байна. 2014 онд шинэчлэлийн Засгийн газрын “11-11.mn” сайтанд 28, 318895 дугаарын утсаар 14, албан бичгээр , өргөдөл, хүсэлтээр 38, нийт 80 мэдээлэл ирснийг судалж хариу мэдэгдэн, харьяалагдах хэлтэс, тасгийн дарга нарт нь мэдэгдэж ёс зүйн зөрчилгүй харилцааны доголдолгүй ажиллахыг гомдолд дурдагдсан татварын улсын /ахлах/ байцаагч нартаа анхааруулж ажиллахыг сануулж, гомдол гаргасан иргэдэд эргэж хариуг мэдэгдэж, шаардлагатай тохиолдолд дотоод хяналт шалгалтын ажлыг явуулж төрийн захиргааны албан хаагчийн болон татварын ажилтны ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд танилцуулга бичиж ТЕГ-ын Ёс зүйн хороогоор асуудлыг шийдвэрлүүлэхээр санал оруулан ажиллаж байна.

Үндэсний Татварын албаны mta.mn, nta.mn болон twitter, facebook хуудсуудаар татварын албаны

нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актуудыг байршуулан байнга шинэчлэн нийтэд нээлттэй ил тод болгох ажлыг хэвшүүлэн ажиллаж байна. “Мэдээлэл харилцан солилцох” гэрээний дагуу Санхүүгийн тайлангийн Е-баланс програмд нэвтрэх кодыг сангийн яамнаас авч зааварчилгаа бэлтгэн татварын албадад цахим шуудангаар хүргүүлсэн. Уг кодыг авснаар татвар төлөгч санхүүгийн тайлангаа өгсөн эсэх болон санхүүгийн тайлангийн мэдээллүүдийг цахим хэлбэрээр харах боломжтой боллоо.

Татварын алба нь татварын тайланг шуудангаар хүлээн авах ийлчилгээг шинээр нэвтрүүлж “Монгол шуудан” ТӨХК-тай хамтран “Албан татварын тайланг шуудангаар дамжуулан хүлээн авах, хянах, буцаан хүргүүлэх журам”-ыг батлан мөрдүүллээ. Тайлан хүлээн авах, хиргэх ийлчилгээнд хамгийн бага тариф ашиглахаар хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр хот дотор 3300, хот хооронд 5500 төгрөгөөр үйлчилж байна.

1.15 Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах

Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурлан гаргах ажлыг ТЕГ-ын Эрсдлийн удирдлагын газарт даалгасан. Татварын албанд хяналт шалгалтын ажил эрхэлсэн татварын улсын /ахлах/ байцаагчид авлигын эрсдэлд өртөх магадлал өндөр байдагтай холбогдуулан УТОХГ, Нийслэл, дүүргийн Татварын албадын татварын хяналт шалгалтын ажил эрхэлсэн татварын улсын (ахлах) байцаагчдын мэргэжлийн ур чадвар, ажлын дадлага туршлагыг үнэлэх, дүгнэх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн 42 хяналт шалгалтын ажил эрхэлсэн татварын улсын байцаагчдын ажлын байрыг сэлгүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Татварын ерөнхий газрын даргын баталсан “Үндэсний татварын албаны авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан “Татварын хяналт шалгалтын ажил эрхэлсэн татварын улсын /ахлах/ байцаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх” ажлын хүрээнд “Авилгын эсрэг хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль, “Үндэсний татварын албаны ёс зүйн дүрэм”-ээр “АХА” тэмцээнийг 2014 оны 11 дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 30 хүртэл 2 үе шаттай зохион байгууллаа.

1.16 Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газарт мэдээлэх

Татварын албаны албан хаагчид албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлига болон ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой аливаа асуудлыг мэдээлэх үүрэгтэй болохыг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль болон “Авлигын эсрэг хууль” мөн Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор Татварын ерөнхий газрын даргын 2012 оны “Хууль, журам хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 553 дугаар тушаалаар баталгаажуулсан.

1.17 Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 “Төрийн байгууллагын байрлаж байгаа байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг

хориглоно” гэсэн зүйл заалтыг Татварын албанд хэрхэн мөрдөх талаарх зөвлөмжийг Авлигатай тэмцэх газраас авсныг Аймаг, дүүргийн Татварын албад руу албан бичгээр хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллахыг даалгаад байна.

1.18 Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх

АТГ-аас ирүүлсэн мэдээллийн ил тод байдлыг хангах зөвлөмжийн дагуу төрийн албаны байгууллагуудын цахим хуудасны стандартын шаардлагад нийцүүлж ТЕГ-ын “mta.mn” сайтад өөрчлөлт хийсэн. Татварын алба бүр өөрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын цахим хуудсанд болон өөрийн мэдээллийн самбарт үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, санхүүгийн тайлан, аудитын тайланг байршуулж ажилласан. АСЗ үүссэн тохиолдолд мэдэгдэл тайлбарыг тухай бүр гаргуулан авч байна. Авлигатай тэмцэх газарт шалгагдсан нэр бүхий 5 албан хаагчийг Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 261 дүгээр шийтгэх тогтоол, Татварын ерөнхий газрын даргын тушаалаар үүрэгт ажлаас нь халж, ТУБ-ийн эрхийг хүчингүй болгосон.

Хоёр. Авлигатай тэмцэх санал, санаачилгын талаар

Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт

Үндэсний Татварын албаны удирдах ажилтны семинар, сургалтын үеэр Авлигатай тэмцэх газар, Монголын залуучуудын холбооноос хамтран зохион байгуулж буй “Авлигаас ангид байх амлалтын дэвтэр”-т Татварын албыг төлөөлсөн ТЕГ, нийслэл, аймаг, дүүргүүдийн татварын хэлтсийн дарга нар гарын үсэг зурж, авлигын эсрэг аянд нэгдэн “Татварын алба-авлигагүй алба” болох зорилт дэвшүүлэн ажиллаж, авлигын эсрэг үйл ажиллагаанд нэгдэн оролцлоо.

Авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд Татварын албад тухай бүр хөрөнгө мөнгө төсөвлөн шийдвэрлүүлж байна. Нийслэлийн татварын газраас санаачлан “Татвар төлөгчтэй уулзах уулзалтын өрөө”-тэй болсон. Уг уулзалтын өрөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх самбар зурагт хуудас байрлуулан компьютер болон бусад тусгай тоног төхөөрөмжөөр тоногдсон.

2015 оны байгууллагын төсөвт Авлигын эсрэг үйл ажиллагаанд тодорхой хэмжээний зардлыг тусган батлуулаад байна.

.....000.....